

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	12
3.2	Үндсэн хөрөнгийн талаар талаар.....	13
3.3	Дотоод аудитын талаар.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн цэвэр мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
5	Аудитын хураангуй тайлангийн хавсралт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

2019.02.25 № 06/259
танай _____-ны № _____-Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны санхүүгийн тайланд:

- Тайлант оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдсэн, өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар баталгаажуулаагүй,
- Тайлант хугацаанд 85,682.5 мянган төгрөгийн авлага, 46,037.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, авлага барагдуулах ажлыг зохион байгуулаагүй,
- Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө, бараа материалын тайланг бэлтгээгүй, 139,596.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө биетээр оршин байхгүй зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, дотоод хяналтын талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Энхжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/653 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсрол, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;
2. Боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх;
3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг шинэчлэх, өргөжүүлэх;

4. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн бодлого, судалгааны боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлж, улс орны хөгжил, нийгмийн сайн сайханд чиглүүлэх;
5. Хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн соёл, урлагийн олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний үйлчилгээний тогтолцоо, соёлын өвийн хамгаалал, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх;
6. судалгаанд суурилсан биеийн тамир, спортын олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний биеийн тамирын үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Биеийн тамир, спортын тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журмын өөрчлөлтүүдийг нэмэлт өөрчлөлтөөр тусгаагүй байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамжийг ашигладаг байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг хангалтгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн *Нийт зардлын 2.0* хувиар сонгов.

Үр дүнгийн тайлангийн *Нийт зардлыг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн орлого зарлагын дүнгээс өндөр байгаа, тус яам нь улсын төсвөөс санхүүждэг, зардлыг мөнгөн сууриар бус аккрузал сууриар тооцох нь илүү бодитой гэж үзсэнтэй холбоотой юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны үр дүнгийн тайлангийн *Нийт зардал* 5,701,994.9 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 114,039.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлын 48.3 хувь буюу 2,758,428.1 мянган төгрөгийг элэгдлийн зардал, 41.3 хувь буюу 2,354,499.8 мянган төгрөгийг цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал эзэлж байгаа ба бусад зардлуудад гүйцэтгэлийн үе шатанд нарийвчилсан горим сорилыг нэмж хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэн материаллаг байдлыг 2.0 хувиар сонгов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 19 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 16 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	140,055.3	
2	Албан шаардлага өгсөн	3	465,467.1	
	Дүн	6	605,522.4	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Авлага, өглөгийн талаар

Тайлант хугацаанд 85,682.5 мянган төгрөгийн авлага, 46,037.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, авлага барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна. Тухайлбал, 1995-1997 онуудад үүссэн 12,799.0 мянган төгрөгийн он дамжсан авлагууд, 2014 оны 4,891.4 мянга төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөгүүд,

Тайлант оны санхүүгийн тайлангаарх авлага, өглөгийн дүн дэлгэрэнгүй бүртгэлээс 44,291.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Үүнд: Авлага 43,530.0 мянга, өглөг 761.0 мянган төгрөгөөр,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

2.8.1.2 Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар

Тайлант хугацаанд яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 3 дугаар сарын А/48 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн ба тооллогоор 139,596.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутсаныг тооллогын комисс шийдвэрлээгүй, жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн тайланг бэлтгээгүй байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар 74,596.9 мянган төгрөгийн бараа материалын тайланг бэлтгээгүй, 35,356.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцооны анхан шатны баримт бүрдэл хангалтгүй,

Техник комиссын дүгнэлт, холбогдох шийдвэргүйгээр 22,217.0 мянган төгрөгийг авто тээврийн хэрэгслийн засварын зардалд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх”,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1-т “үндсэн хөрөнгө, ... тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 1-нээс 31-ны дотор/, 72 дугаар зүйлийн 3-т “... хөрөнгийн хадгалалт хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, ... урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хуульд заасан хугацаанд хийж, тайланг бэлтгэж байх, тооллогоор дутсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож нөхөн төлүүлэх, хөрөнгийг зарцуулахдаа анхан шатны баримт бүрдлийг хангах талаар албан шаардлага хүргүүлэв.

2.8.1.3 Нэмэлт санхүүжилтийн талаар

Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж байгаа Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сан болон бусад холбогдох төслүүдийн тайланг бэлтгээгүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан

гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 22 дугаар зүйлийн 22.6.3-т “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх”, 22.6.7-д “төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг ... заасан ангиллаар бүртгэж, тайлагнах”, 22.2.3-д “эдийн засгийн ангиллаар”, 22.2.4-д “хөтөлбөрөөр”, 22.2.5-д “арга хэмжээгээр”, 22.2.6-д “санхүүжүүлэх эх үүсвэрээр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж буй зардлын тайланг бэлтгэн, хяналт тавих талаар албан шаардлага хүргүүлэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар цалингийн тооцоолол, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж байгаа төслийн зардлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 4 арга хэмжээнд зориулан тайлант онд 2,284,741.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардал ба цэвэр зээл 2,244,158.9 мянган төгрөг буюу 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал зардал 40,582.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 31.5 хувь буюу 26,768.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь голлон нөлөөлжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу байршуулан ажиллаж байна.

Жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг бэлтгээгүй байгаа бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 219 гүйлгээ, орлогын 128 гүйлгээ, 33 тушаал шийдвэрийг цахим хуудсанд мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгсөн бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар 2 зөвлөмж хэрэгжиж, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөгтэй холбоотой 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, цахим баримтыг бүрэн хавсаргаагүй, бараа материалыг шууд зардалд бүртгэсэн байна. Тухайлбал: 3,297.9 мянган төгрөгийн зөөврийн компьютер, багаж хэрэгслийг шууд зардалд бүртгэсэн, 30,100.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, 77,676.0 мянган төгрөгийн тусламжийг эд хогшил, урсгал засварын зардалд бүртгэсэн,

Урьд оны үлдэгдлээс 61,220.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан бөгөөд 28,981.4 мянган төгрөг нь Сангийн сайдын тушаалаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал 6 дугаар хавсралтад “Багаж, техник, хэрэгсэл – Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар ашиглахаар худалдан авсан багаж, хэрэгсэл ...”, “Тавилга - ... байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэгдэх тавилгыг цөөн тоотойгоор худалдан авах зардлыг ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Зардалд бүртгэлээр тавих хяналт сулрах, үргүй зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын холбогдох журмуудыг мөрдөж ажиллах,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар талаар

3.2.1 Илрүүлэлт:

Тус яам нь Засгийн газрын 3 дугаар байрны 3,060.6 мкв талбайг ашигладаг бөгөөд 34.5 мкв талбайд кофе шоп үйл ажиллагаагаа явуулж байна. Кофе шоптой байгуулсан гэрээ, эрх зүйн акт баримтаар нотлогдоогүй,

Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг сольсныг холбогдох баримтаар баталгаажуулаагүй байна. Тухайлбал, улсын дугаар солих тухай тэмдэглэл, өөрчлөлт оруулсан тээврийн хэрэгслийн гэрчилгээг хавсаргаагүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгийн шамшигдал үүсэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.3 Дотоод аудитын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Дотоод аудитын нэгж нь төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн явцад хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоол “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.6-д “Дотоод аудитор нь зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавина”, 6.7-д “Дотоод аудитын нэгжийн дарга дараах асуудлаар төсвийн ерөнхийлөн захирагч ... -д тайлагнана”, 6.7.3-т “дотоод аудит болон хөндлөнгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн явц” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Зөрчил арилахгүй байх, зөрчил давтагдан гарах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийг мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	177,982,703.50	168,049,358.99
33	АВЛАГА	82,764,234.00	85,682,486.99
33300	Татаас санхүүжилтийн авлага	61,220,364.00	62,710,636.99
335	Бусад авлага	21,543,870.00	22,971,850.00
3351	Байгууллагаас авах авлага	21,543,870.00	22,971,850.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,770,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,770,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	95,218,469.50	74,596,872.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	23,403,400.00	9,820,000.00
354	Хангамжийн материал	71,815,069.50	64,776,872.00
35410	Бичиг хэргийн материал	9,169,537.50	5,629,060.00
35420	Аж ахуйн материал	32,493,332.00	19,651,612.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,646,000.00	3,646,000.00
35440	Түлш шатах тослох материал	-	7,180,000.00
35470	Бусад хангамжийн материал	26,506,200.00	28,670,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,571,385,223.83	11,814,777,779.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,571,385,223.83	11,814,777,779.34
392	Биет хөрөнгө	9,522,862,503.96	7,392,007,824.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	420,282,850.00	420,282,850.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-302,198,983.77	-386,341,958.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,290,519,765.68	10,291,505,565.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,255,235,413.16	-3,248,310,051.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	597,110,132.26	597,945,032.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-227,615,847.05	-283,073,613.27
393	Биет бус хөрөнгө	5,048,522,719.87	4,422,769,954.99
39301	Програм хангамж	5,068,145,178.32	5,068,145,178.32
	Хасагдуулга	-19,622,458.45	-645,375,223.33
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,749,367,927.33	11,982,827,138.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,233,993.44	70,084,160.59
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,233,993.44	70,084,160.59
413	Өглөг	38,233,993.44	70,084,160.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	29,407,794.93	56,163,491.63
	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,891,370.00	4,891,370.00
4136	Бусад өглөг	3,934,828.51	9,029,298.96
41361	Байгууллагад төлөх өглөг	679,974.36	9,029,298.96
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,254,854.15	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,711,133,933.89	11,912,742,977.74
51	Засгийн газрын хувь оролцоо	14,711,133,933.89	11,912,742,977.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,135,349,477.27	1,135,349,477.27
51101	Өмч: - төрийн	1,135,349,477.27	1,135,349,477.27
512	Хуримтлагдсан үр дүн	13,575,784,456.62	10,777,393,500.47
51210	Өмнөх үеийн үр дүн	13,575,784,456.62	13,568,636,132.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	-2,791,242,631.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,749,367,927.33	11,982,827,138.33

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,023,851,719.64	2,928,887,677.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,132,510,576.64	62,042,370.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,132,510,576.64	62,042,370.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,132,510,576.64	62,042,370.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,675,064.64	62,042,370.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,122,835,512.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,891,341,143.00	2,866,845,307.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,504,160,237.00	2,278,241,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,504,160,237.00	2,278,241,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	387,180,906.00	588,603,607.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	264,192,606.00	588,603,607.99
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	116,523,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,464,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,543,811,861.95	5,720,130,309.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,543,811,861.95	5,720,130,309.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,316,458,725.78	5,560,623,192.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,576,159,349.90	1,533,379,063.45
210101	Үндсэн цалин	1,568,640,155.90	1,131,513,362.38
210102	Нэмэгдэл цалин	2,374,794.00	116,445,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,144,400.00	93,597,101.43
210104	Урамшуулал	-	191,823,099.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,991,865.88	182,109,496.99
210201	Тэтгэврийн даатгал	115,312,869.98	121,406,331.33
210202	Тэтгэмжийн даатгал	12,633,039.88	15,175,791.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,900,074.90	12,140,633.13
210204	Ажилгүйдлийн даатгал	5,061,638.58	3,035,158.28
210205	Эрүүл мэндийн даатгал	31,084,242.54	30,351,582.83
2104	Хангамж, бараа материалын зардал	154,339,418.01	162,490,902.76
210401	Бичиг хэрэг	23,746,970.00	67,113,987.70
210402	Тээвэр, шатахуун	23,934,875.00	35,356,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,103,073.01	20,485,598.06
210404	Ном, хэвлэлийн зардал	65,192,020.00	1,436,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,362,480.00	12,390,247.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	25,709,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,899,614.00	132,532,623.00
210601	Багаж хэрэгсэл	-	17,305,803.00
210602	Тавилга	-	64,156,000.00
210604	Урсгал засвар	15,899,614.00	51,070,820.00
2107	Томилолт, зочны зардал	27,774,648.00	58,685,526.00
210701	Гадаад томилолтын зардал	10,348,668.00	-
210702	Дотоод томилолтын зардал	17,425,980.00	58,685,526.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	358,396,752.46	663,058,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,676,122.46	650,932,060.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	3,766,730.00	3,898,000.00

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,900.00	737,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	77,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,433,000.00	7,413,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,005,897,077.53	2,828,367,520.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,146,333.16	3,573,600.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	60,492,031.00	66,365,776.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	780,258,713.37	2,758,428,144.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	227,353,136.17	159,507,116.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,557,575.00	3,132,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,557,575.00	3,132,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,039,237.00	86,885,366.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	92,049,982.00	58,231,766.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,717,255.00	28,653,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,272,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,756,324.17	69,489,750.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,756,324.17	69,489,750.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,480,039,857.69	-2,791,242,631.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	35,126,585.79	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35,126,585.79	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-35,126,585.79	-
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,444,913,271.90	-2,791,242,631.55

4.3 Аудит хийсэн цэвэр мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,939,639,552.46</u>	<u>2,990,558,041.99</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,455,328.46	62,492,370.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,455,328.46	62,492,370.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	43,455,328.46	62,492,370.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,455,328.46	62,492,370.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,896,184,224.00	2,928,065,671.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,504,160,237.00	2,278,241,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,504,160,237.00	2,278,241,700.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	28,981,413.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	387,180,906.00	620,842,558.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	264,192,606.00	588,603,607.99
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУ-ын байгууллага	116,523,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,464,500.00	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих - Нэмэлт	-	32,238,951.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,843,081.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,843,081.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,858,079,151.46</u>	<u>2,988,737,341.99</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,858,079,151.46	2,988,737,341.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,569,505,651.29	2,766,519,588.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,571,279,618.70	1,513,997,299.68
210101	Үндсэн цалин	1,370,765,058.41	1,111,716,700.00
210102	Нэмэгдэл	12,723,760.00	116,445,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,186,400.00	94,012,000.00
210104	Урамшуулал	106,460,000.29	191,823,099.68
210105	Гэрээт ажлын хөлс	5,144,400.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,654,174.00	177,990,418.21
210201	Тэтгэврийн даатгал	99,689,019.82	146,633,055.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,393,030.83	14,188,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,241,288.54	11,350,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,848,257.7	-
210205	Эрүүл мэндийн даатгал	28,482,577.11	5,818,763.21
2104	Хангамж, бараа материалын зардал	180,214,335.51	138,626,185.26
210401	Бичиг хэрэг	36,550,007.50	52,879,620.00
210402	Тээвэр, шатахуун	23,934,875.00	46,306,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,103,073.01	20,694,678.26
210404	Ном, хэвлэл	73,825,420.00	3,352,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,800,960.00	15,393,887.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,056,614.00	138,965,623.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	220,000.00	16,817,903.00
210602	Тавилга	-	64,156,000.00
210604	Урсгал засвар	15,836,614.00	57,991,720.00
2107	Томилолт, зочны зардал	27,774,648.00	58,685,526.00
210701	Гадаад албан томилолт	10,348,668.00	-
210702	Дотоод албан томилолт	17,425,980.00	58,685,526.00

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	357,871,106.46	662,677,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,150,476.46	650,551,060.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,766,730.00	3,898,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,900.00	737,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	77,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,433,000.00	7,413,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	259,655,154.62	75,577,476.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,163,123.62	9,211,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,492,031.00	66,365,776.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	288,573,500.17	222,217,753.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,557,575.00	3,132,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,557,575.00	3,132,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,039,237.00	86,885,366.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	92,049,982.00	58,231,766.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,717,255.00	28,653,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,272,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,976,688.17	132,200,387.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,976,688.17	132,200,387.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>81,560,401.00</u>	<u>1,820,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,820,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,820,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,820,700.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	1,820,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>-1,820,700.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>81,560,401.00</u>	=
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	1,130,871,184.72	2,266,220,661.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	60,273,866.00	60,273,866.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	1,191,145,050.72	2,326,494,527.99
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн	-	-	12,384,639,405.90	12,384,639,405.90
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	13,575,784,456.62	14,711,133,933.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-7,148,324.60	-7,148,324.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	13,568,636,132.02	14,703,985,609.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			-2,791,242,631.55	-2,791,242,631.55
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	0.00	10,777,393,500.47	11,912,742,977.74

4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Тайлант оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,284,741,700.00	2,244,158,892.15	40,582,807.85	98.2
УРСГАЛ ЗАРДАЛ	2,284,741,700.00	2,244,158,892.15	40,582,807.85	98.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,166,088,100.00	2,154,141,526.15	11,946,573.85	99.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,504,097,300.00	1,504,097,299.68	0.32	100.0
Үндсэн цалин	1,101,816,700.00	1,101,816,700.00		100.0
Нэмэгдэл	116,445,500.00	116,445,500.00		100.0
Унаа хоолны хөнгөлөлт	94,012,000.00	94,012,000.00		100.0
Урамшуулал	191,823,100.00	191,823,099.68	0.32	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,441,100.00	177,990,418.21	4,450,681.79	97.6
Тэтгэврийн даатгал	125,688,700.00	146,633,055.00	-20,944,355.00	116.7
Тэтгэмжийн даатгал	14,188,100.00	14,188,100.00		100.0
ҮОМШ өвчний даатгал	11,350,500.00	11,350,500.00		100.0
Ажилгүйдлийн даатгал	2,837,600.00	-	2,837,600.00	-
Эрүүл мэндийн даатгал	28,376,200.00	5,818,763.21	22,557,436.79	20.5
Хангамж, бараа материалын зардал	90,731,000.00	90,730,785.26	214.74	100.0
Бичиг хэрэг	21,726,800.00	22,334,220.00	-607,420.00	102.8
Тээвэр, шатахуун	28,315,000.00	28,306,000.00	9,000.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,293,200.00	20,694,678.26	598,521.74	97.2
Ном, хэвлэл	3,352,000.00	3,352,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,044,000.00	16,043,887.00	113.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	58,000,000.00	57,991,720.00	8,280.00	100.0
Урсгал засвар	58,000,000.00	57,991,720.00	8,280.00	100.0
Томилолт, зочны зардал	7,511,100.00	3,762,526.00	3,748,574.00	50.1
Дотоод албан томилолт	7,511,100.00	3,762,526.00	3,748,574.00	50.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,050,700.00	311,311,877.00	3,738,823.00	98.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,277,200.00	299,185,877.00	3,091,323.00	99.0
Даатгалын үйлчилгээ	3,898,000.00	3,898,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	776,500.00	737,200.00	39,300.00	94.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	77,800.00	21,200.00	78.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,000,000.00	7,413,000.00	587,000.00	92.7
Бараа үйлчилгээний бусад зардал	8,256,900.00	8,256,900.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	8,256,900.00	8,256,900.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,653,600.00	90,017,366.00	28,636,234.00	75.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,000,000.00	3,132,000.00	1,868,000.00	62.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	5,000,000.00	3,132,000.00	1,868,000.00	62.6

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад урсгал шилжүүлэг	113,653,600.00	86,885,366.00	26,768,234.00	76.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	85,000,000.00	58,231,766.00	26,768,234.00	68.5
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,653,600.00	28,653,600.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,284,741,700.00	2,244,158,892.15	40,582,807.85	98.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,278,241,700.00	2,237,658,892.15	40,582,807.85	98.2
Улсын төсвөөс санхүүжих	2,278,241,700.00	2,237,658,892.15	40,582,807.85	98.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,500,000.00	6,500,000.00	-	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,500,000.00	6,500,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
Төсвөөс бусад мэдээллийн ангилал				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	106	106	-	100.0
Удирдах ажилтан	14	14	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	92	92	-	100.0
Суралцагчдын тоо /жилийн дунджаар/				
ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО				

5 Аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/374/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал
1	Тайлант хугацаанд 85,682.5 мянган төгрөгийн авлага, 46,037.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, авлага барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна. Тайлант оны санхүүгийн тайлангаарх авлага, өглөгийн дүн дэлгэрэнгүй бүртгэлээс 44,291.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.	193,701.2	Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга	Б.Баярсайхан
				Нягтлан бодогч	Б.Уранбилэг
2	Үндсэн бараа материал үндсэн хөрөнгийн тайланг бэлтгээгүй, үндсэн хөрөнгийн тооллогоор 139,596.0 мянган төгрөгийн хөрөнгө дутсаныг тайлант хугацаанд шийдвэрлээгүй байна.	271,765.9	Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга	Б.Баярсайхан
				Нягтлан бодогч	Б.Уранбилэг
3	Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж байгаа НҮБ-ийн хүн амын сан болон бусад холбогдох төслүүдийн тайланг нэгтгэн дүгнээгүй, үр дүнг тооцож тайлагнаагүй байна.	-	Албан шаардлага	Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга	Т.Ням-Очир
				Сургуулийн өмнөх бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч	Г.Дуламжав
4	Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй	140,055.3	Зөвлөмж	Төрийн нарийн бичгийн дарга	Б.Баярсайхан
				Нягтлан бодогч	Б.Уранбилэг
Нийт дүн		605,522.4			